

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..	8
2.8.1.1	Санхүүгийн тайлангийн залруулга	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЗОРИГТ ТАНАА

2019.02.25 № 06/217
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.


Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_KheregiYawsan_Bichig\2019\0224SAG6.Docx



Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг НДЕГ-ын дарга Д.Зоригт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газрт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх эрхэм зорилготой ажилладаг бөгөөд 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзлэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэнэ.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;
- нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;

- улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;
- хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ НДЕГ-ын харьяа Мэдээллийн технологийн төвийн нягтлан бодох бүртгэлийн “Санхүү” програм хангамж ашигладаг байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Нийгмийн даатгалын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь гүйцэтгэлийн үе шатанд үйл ажиллагааны бус зардлын дүн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалан эрс өсч нийт зардал нь бодитой бус илэрхийлэгдсэн тул нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны нийт орлого 3,277,9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 65,559.17 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон төлөвлөлтийн үе шатанд сонгосон материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	2,276.5	
2	Албан шаардлага	1	4,422.6	
	Дүн	3	6,699.1	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Санхүүгийн тайлангийн залруулга

Мөнгөн гүйлгээний тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 88,108.9 мянган төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 1,380.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад 89,489.1 мянган төгрөгийн алдааг залруулсан

2.8.1.2 Үндсэн хөрөнгө

Барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй автомашины 1 граж байршил нь тодорхойгүй шалтгаанаар дахин үнэлгээ хийгдээгүй, 2 граж дахин үнэлгээ хийгдсэнээс 1 граж нь олон жилийн өмнө зарагдаж өөр эзэмшигчтэй болсон боловч байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

НДЕГ-ын туслах үйл ажиллагааны орлого 175,144.1 мянган төгрөг болж өмнөх оноос 29,568.0 мянган төгрөгөөр өссөн боловч орлогын төлөвлөгөөг жил бүр 86,334.4 мянган төгрөгөөр төсөвлөдөг байна.

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг зөвхөн НДЕГ-ын хэмжээнд төсөвлөдөг бөгөөд өмнөх онд 246,835.0 мянган төгрөг, тайлант онд 403,483.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөнөөс аймаг нийслэлийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн туслах үйл ажиллагааны орлогын 268,706.3 мянган төгрөгийг орлогын төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “төсвийн зарчмыг мөрдлөг болгох” гэсэн шаардлагад нийцүүлж төсвийн төслийг боловсруулах гэж заасантай нийцэхгүй байна.

Тус байгууллагын 3 албан хаагчтай холбоотой нийт 48,694.7 мянган төгрөгийн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаатай холбоотой төлбөр тогтоогдож 35,404.3 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулж 13,290.4 мянган төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Дээрх шийдвэрүүд нь 2016-2017 онуудад гарсан шийдвэр боловч тайлант онд 25,404.3 мянган төгрөгийг холбогдох хүмүүст төлсөн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,558,672.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,445,508.9 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь төсөвлөсөн маягтын зардал зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант онд нийт 160 мэдээлэл мэдээлэхээс 29 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7 зөвлөмж, 2 албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 96.4 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлага, өр төлбөрийн тооцоо

3.1.1 Илрүүлэлт:

Харилцагч татварын байгууллагатай нийлсэн тооцоог тулган шалгахад тайлант оны эцэст 1,327.7 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа боловч өмнөх оноос зөрүүтэй тайлагнасан 97,432.4 мянган төгрөгийн эхний үлдэгдлийн илүү төлөлтийн тооцооны алдааг залруулаагүй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийн өмнөх оны үлдэгдэл 5.7 сая төгрөгөөс тайлант онд суутган тооцоо хийж 948.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах, татварын байгууллагатай тооцоо нийлж эхний үлдэгдлийн зөрүүг залруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

3.2 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж

3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн програмаас гарсан тайлан нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллаар тайлагнаагүй, дансны төлөвлөгөө тодорхойгүй, ерөнхий дэвтэр ойлгомжгүй, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүн давхардаж тайлагнагдах зэрэг алдаа гарч байна.

Мөн тус програмд аудит цэс байхгүйгээс СТАУС програмд санхүүгийн тайлан, тодруулгыг гараар шивж оруулсан байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн нягтлан бодох бүртгэлийн зарчимтай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн програм хангамж нь алдаатай ажилладаг, санхүүгийн тайлан, журналыг буруу бэлтгэн гаргадаг байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримталж ажиллах, санхүүгийн програмын шинэчлэл хийлгэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	264,981,316.06	280,173,996.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,108,973.10	122,665,389.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	88,108,973.10	122,665,389.49
3121	Төгрөг	88,108,973.10	122,665,389.49
31211	Төрийн сангийн харилцах	88,108,973.10	122,665,389.49
33	АВЛАГА	73,930,373.44	57,490,324.22
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	7,446,211.00	2,265,854.22
335	Бусад авлага	66,484,162.44	55,224,470.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	66,484,162.44	55,224,470.00
34	УРЬДЧИЛГАА	1,177,284.50	-
3471	Урьдчилгаа тооцоо	1,177,284.50	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,177,284.50	-
35	БАРАА МАТЕРИАЛ	101,764,685.02	100,018,283.18
354	Хангамжийн материал	101,764,685.02	100,018,283.18
35410	Бичиг хэргийн материал	11,632,349.29	8,096,727.45
35420	Аж ахуйн материал	88,981,446.73	84,264,632.73
35430	Сэлбэг хэрэгсэл	1,150,889.00	7,656,923.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,388,621,004.21	5,811,646,862.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,388,621,004.21	5,811,646,862.11
392	Биет хөрөнгө	8,357,236,082.21	5,702,741,490.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,525,802,255.78	5,053,156,270.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(606,139,817.71)	(1,980,000.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	551,560,000.00	406,680,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(258,348,239.29)	(288,658,517.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,188,106,726.40	881,440,268.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(523,803,800.31)	(557,668,101.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	724,495,561.68	422,448,652.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(244,436,604.34)	(212,677,081.21)
393	Биет бус хөрөнгө	31,384,922.00	49,097,951.50
39301	Програм хангамж	36,205,528.00	65,845,386.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(21,158,623.00)	(24,916,443.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,676,034.00	32,676,034.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(16,338,017.00)	(24,507,025.50)
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	59,807,420.00
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		59,807,420.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,653,602,320.27	6,091,820,859.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,191,998.53	5,092,163.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,191,998.53	5,092,163.89
413	Өглөг	17,191,998.53	5,092,163.89
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,724,938.51	1,615,554.43
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,182,153.63
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		50,000.00

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4136	Бусад өглөг	11,467,060.02	2,244,455.83
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	11,467,060.02	2,244,455.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,636,410,321.75</u>	<u>6,086,728,695.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,636,410,321.75	6,086,728,695.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,081,931,975.98	2,141,739,395.98
51101	Өмч: - төрийн	2,081,931,975.98	2,141,739,395.98
512	Хуримтлагдсан үр дүн	5,904,189,580.95	2,257,362,507.41
51210	Өмнөх үеийн үр дүн	5,904,189,580.95	5,883,308,265.99
51220	Тайлант үеийн үр дүн		(3,625,945,758.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	650,288,764.82	1,687,626,791.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,653,602,320.28</u>	<u>6,091,820,859.00</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/
		Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	3,342,092,768.23	3,259,879,621.40
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,196,516,584.71	2,804,770,911.30
Улсын төвлөрсөн төсвөөс	3,110,676,581.71	2,572,227,837.30
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,031,361,300.00	2,472,338,400.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	79,315,281.71	99,889,437.30
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,840,003.00	232,543,074.00
Гэрэл, цахилгаан	34,915,648.60	23,369,196.49
Түлш, халаалт	28,021,211.00	13,876,361.00
Цэвэр, бохир ус	11,242,503.00	2,930,204.59
Байрны түрээс	72,277,442.42	72,459,563.35
Бичиг хэрэг	22,068,550.42	29,834,631.94
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	315,238,368.39	479,535,622.58
Бусад урсгал шилжүүлэг	177,517,970.00	189,134,587.10
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	73,892,300.00	19,869,300.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,524,670.00	149,109,450.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	137,720,398.39	290,401,035.48
Төвлөрүүлэх шилжүүлэг	137,720,398.39	290,401,035.48
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	481,944,694.24	394,944,068.43
Догоод эх үүсвэрээр	481,944,694.24	394,944,068.43
Бусад хөрөнгө	481,944,694.24	394,944,068.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(303,874,110.62)	(80,176,108.69)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,239,290,807.60	18,079,052.33
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	45,003.92	18,079,052.33
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,239,245,803.68	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	71,076,393.21	3,563,848,702.22
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	68,331,882.89	2,397,800,167.35
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,648,510.32	6,439,370.29
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	96,000.00	1,159,609,164.58
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	2,168,214,414.40	(3,545,769,649.89)
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,864,340,303.78</u>	<u>(3,625,945,758.58)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,200,007,949.15</u>	<u>3,549,402,055.08</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,491,364.44	569,487,035.35
120	Нийтлэг татварын бус орлого	3,491,364.44	569,487,035.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	839,055.44	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	839,055.44	
120009	Бусад орлого	2,652,309.00	569,487,035.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,196,516,584.71	2,979,915,019.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,840,003.00	232,543,074.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,840,003.00	232,543,074.00
1330	Төсвийн захирагчдаас	79,315,281.71	275,033,545.73
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		175,144,108.43
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,315,281.71	99,889,437.30
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,031,361,300.00	2,472,338,400.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,031,361,300.00	2,472,338,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,175,701,827.12</u>	<u>3,508,880,138.48</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,175,701,827.12	3,508,880,138.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,860,463,458.73	3,029,444,515.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,982,570,595.09	1,599,800,109.94
210101	Үндсэн цалин	1,877,161,495.09	1,276,460,801.54
210102	Нэмэгдэл	105,409,100.00	323,339,308.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	203,341,017.41	156,031,072.77
210201	Тэтгэврийн даатгал	129,324,887.07	104,447,200.12
210202	Тэтгэмжийн даатгал	16,673,963.43	12,903,769.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,673,963.43	10,313,653.91
210204	Ажилгүйдлийн даатгал	3,660,138.31	2,574,512.70
210205	Эрүүл мэндийн даатгал	37,008,065.17	25,791,936.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,456,805.02	112,635,325.43
210301	Гэрэл, цахилгаан	34,915,648.60	23,369,196.49
210302	Түлш, халаалт	28,021,211.00	13,876,361.00
210303	Цэвэр, бохир ус	11,242,503.00	2,930,204.59
210304	Байрны түрээс	72,277,442.42	72,459,563.35
2104	Хангамж, бараа материалын зардал	87,782,290.67	94,692,952.05
210401	Бичиг хэрэг	23,367,664.07	26,161,937.80
210402	Тээвэр, шатахуун	11,402,817.32	9,144,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,579,684.19	31,488,411.45
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	681,600.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,750,525.09	27,298,102.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,547,700.00	26,535,501.20

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	385,000.00	6,506,034.00
210604	Урсгал засвар	16,162,700.00	20,029,467.20
2107	Томилолт, зочны зардал	49,127,664.64	50,205,988.80
210702	Дотоод албан томилолт	49,127,664.64	50,205,988.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,222,555.90	788,161,218.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	181,943,594.51	200,920,588.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,346.00	1,165,709.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,944,250.00	8,181,025.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	644,140.00	723,758.00
210807	Газрын төлбөр	1,184,776.00	999,104.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,497,449.39	10,353,294.86
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		565,817,739.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,414,830.00	201,382,347.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	178,414,830.00	201,382,347.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	315,238,368.39	479,435,622.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	177,517,970.00	189,134,587.10
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	177,517,970.00	169,265,287.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,869,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	137,720,398.39	290,301,035.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	137,720,398.39	290,301,035.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>24,306,122.03</u>	<u>40,521,916.60</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	2,648,510.32	5,965,500.21
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	2,648,510.32	5,965,500.21
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(2,648,510.32)</u>	<u>(5,965,500.21)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	21,657,611.71	34,556,416.39
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,451,361.39	88,108,973.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,108,973.10	122,665,389.49

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,081,931,975.98	650,288,764.82	4,039,849,277.17	6,772,070,017.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,081,931,975.98	650,288,764.82	4,039,849,277.17	6,772,070,017.97
C07	Тайлант үеийн үр дүн			1,864,340,303.78	1,864,340,303.78
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,081,931,975.98	650,288,764.82	5,904,189,580.95	8,636,410,321.75
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,081,931,975.98	650,288,764.82	5,904,189,580.95	8,636,410,321.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-20,881,314.96	-20,881,314.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,081,931,975.98	650,288,764.82	5,883,308,265.99	8,615,529,006.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,037,338,026.90		1,037,338,026.90
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	59,807,420.00			59,807,420.00
D08	Тайлант үеийн үр дүн			(3,625,945,758.58)	-3,625,945,758.58
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,141,739,395.98	1,687,626,791.72	2,257,362,507.41	6,086,728,695.11

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,558,672,800.00	2,445,508,939.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,558,672,800.00	2,445,508,939.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,483,229,700.00	2,370,060,189.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,592,859,400.00	1,586,834,618.01
210101	Үндсэн цалин	583,003,800.00	1,135,556,375.41
210102	Нэмэгдэл	779,810,800.00	224,249,328.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	103,241,000.00	103,151,200.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээг ажлын хөлс	126,803,800.00	123,877,714.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,447,100.00	160,959,082.24
210201	Тэтгэврийн даатгал	115,070,800.00	107,746,009.66
210202	Тэтгэмжийн даатгал	12,844,100.00	13,311,316.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,275,300.00	10,639,395.34
210204	Ажилгүйдлийн даатгал	2,568,800.00	2,655,824.85
210205	Эрүүл мэндийн даатгал	25,688,100.00	26,606,536.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,010,500.00	125,958,567.94
210301	Гэрэл, цахилгаан	34,351,000.00	34,351,000.00
210302	Түлш, халаалт	16,217,800.00	16,217,800.00
210303	Цэвэр, бохир ус	4,578,300.00	2,930,204.59
210304	Байрны түрээс	73,863,400.00	72,459,563.35
2104	Хангамж, бараа материалын зардал	95,184,200.00	96,811,063.40
210401	Бичиг хэрэг	26,230,700.00	26,161,937.80
210402	Тээвэр, шатахуун	9,156,200.00	9,144,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,755,400.00	33,606,522.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	681,600.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,360,300.00	27,298,102.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,547,700.00	16,535,501.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,462,700.00	6,506,034.00
210604	Урсгал засвар	10,085,000.00	10,029,467.20
2107	Томилолт, зочны зардал	50,206,000.00	49,731,988.80
210702	Дотоод албан томилолт	50,206,000.00	49,731,988.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	312,803,300.00	213,847,610.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,233,000.00	142,972,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,950,000.00	4,950,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,874,000.00	11,739,857.73
210804	Тээврийн хэрэгслийн татвар	990,000.00	723,758.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,422,500.00	38,422,500.00
210807	Газрын төлбөр	4,685,300.00	4,685,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,648,500.00	10,353,294.86
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	99,000,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,171,500.00	119,381,757.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,171,500.00	119,381,757.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,443,100.00	75,448,750.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,443,100.00	75,448,750.47
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,605,000.00	24,610,650.47
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,869,300.00	19,869,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,968,800.00	30,968,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,558,672,800.00	2,443,847,743.65
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,472,338,400.00	2,362,461,421.22
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,472,338,400.00	2,362,461,421.22
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	86,334,400.00	81,386,322.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,334,400.00	81,386,322.43
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		88,108,973.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		86,447,777.10
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	97.00	97.00
620001	Удирдах ажилтан	11.00	11.00
620002	Гүйцэтгэх ажилтан	86.00	86.00

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019-02-24	Аудитын нэр:	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Нийгмийн даатгалын ерөнхий газар				САГ-2019/405/СТА-ТШЗ
					Мянган төгрөгөөр

д д	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
	1		2	3			4	5
1	Үндсэн хөрөнгө	Хөрөнгийн дансанд бүртгэлтэй автомашины 2 граж бодитоор оршин байхгүй	4,422.6	Албан шаардлага			Дарга Нягтлан бодогч	Д.Зоригт П.Адьяасүрэн
2	Авлага, өр төлбөр	Татвар, НДШ-ийн өр авлага бүртгэсэн	2,276.5	Зөвлөмж өгөх			Дарга Нягтлан бодогч	Д.Зоригт П.Адьяасүрэн
3	Санхүүгийн програм хангамж	Санхүүгийн програм хангамж шинэчлэл хийгээгүй		Зөвлөмж өгөх			Дарга Нягтлан бодогч	Д.Зоригт П.Адьяасүрэн
		ДҮН	6,699.1					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2018
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/405/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор Ж.Болормаа
Утас: 261628 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn
Аудитор Э.Энхбаатар
Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn